



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН
ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор:
Х.Түвшинбаяр
Утас: 70483413

Аудитын менежер:
Утас: 70484055
Цахим хаяг:

Шинжээч:
Г.Энхдэлгэр
Утас: 70484030

ТАБ-ын хаяг: ҮАГ-ын харьяа
Говь-Алтай аймгийн
Аудитын газар
Байршил: Говь-Алтай,
Есөнбулаг сум

2016 оны 1 дүгээр сар

Хавсралт1: Агуулга

Хавсралт2: Аудитын гэрчилгээ

Хавсралт3: Төлбөр зөрчлийн жагсаалт

Хавсралт4: Акт, албан шаардлага

Хавсралт5: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт6: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

ХУУДАС

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэл, үр дагавар
9. Санхүүгийн тайлан, гол онцлог гүйлгээ, түүний талаар тайлбар
10. Аудитаар илэрсэн зөрчлүүд болон тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын дүгнэлт

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТ	Санхүүгийн тайлан
ЗД	Засаг дарга
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЖДҮДТ	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын харьяа орон нутаг дахь Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт бөгөөд Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 1 сарын 4-нээс 2016 оны 1 сарын 6-ны хооронд хийхээр төлөвлөсөн боловч тус байгууллага санхүүгийн тайлангаа 1 сарын 6-нд ирүүлж, мөн аудитын төлөвлөлтийг СТАУС программд шинээр хийсэнтэй холбоотойгоор аудитыг 1 сарын 6-наас 1 сарын 11-ний хооронд хийж гүйцэтгэв.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, жижиг дунд үйлдвэрийг дэмжих замаар орон нутагт бий болох ажлын байрыг дэмжих үйлчилгээг иргэн аж ахуйн нэгж байгууллагад чанартай хүртээмжтэй хүргэх” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого зарчмуудыг үнэлж ажил гүйлгээ, үлдэгдлийг бүгдийг анхан шатын баримтаас журнал, тайлан руу хөөн шалгах горимыг гүйцэтгэв. / ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хөдөлмөрийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2012 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн программ нийцсэн байна.

Хөдөлмөрийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хөдөлмөрийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хөдөлмөрийн хэлтсийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед " бага " гэж тооцсон ба хянан үзэхэд дотоод хяналт хариуцсан орон тооны мэргэжилтэн байдаг бөгөөд жилийн ажлын төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан холбогдох албан тушаалтнаар батлуулан ажилладаг байна. Гэвч аудитаар илэрч буй зөрчлөөс дүгнэхэд дотоод хяналтын ажлыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Говь-Алтай аймгийн Хөдөлмөрийн хэлтэс нь урсгал зардалд 307,193.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 293,559.6 мянган төгрөгөөр санхүүжиж урсгал санхүүжилтийг 13,633.6 мянган төгрөгөөр дутуу авч үйл ажиллагаандаа 274,236.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тайлант онд батлагдсан төсвийг 19,323.1 мянган төгрөгөөр хэмнэн, хэмнэсэн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2014 оны "Эдийн засгийн ангилал батлах тухай" 05 дугаар тушаалын дагуу бүлэглэн тооцоход төсөв хэтрүүлэн зарцуулаагүй байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар үзэхэд 2016 оны мэдээллийг шивж оруулсан байна. Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангуулах зорилготой юм.

Олж тогтоосон гол эрсдэл, үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 21 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан олгосон, үндэслэлгүй цалин олгосон, Засгийн газрын тогтоолыг зөрчин "Хөдөлмөрийн хэлтсийн байрны өргөтгөлийн барилгын ажил"-ын гэрээг 2015 оны 12 сарын 18-нд байгуулсан, Сумдад ахуй үйлчилгээний төв байгуулах зорилгоор хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сумдаас судалгаа авахад "зах зээлийн ханшаас өндөр үнэтэй, чанарын шаардлага хангахгүй байгаа, сургалтанд хамрагдсан иргэн байхгүй" гэсэн шалтгаанаар түрээсийн гэрээ хийх иргэн ховор байгаа нь уг ажил үр дүн муутай байгааг харуулж байгаа, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон нөхөн төлбөрийг төсвөөс төлсөн, санхүүжилтыг батлагдсан төсвөөс дутуу авсан, санхүүгийн байдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайланг зөрүүтэй тайлагнасан нийт 21,468.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Тус зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлан, гол онцлог гүйлгээ, түүний талаар тайлбар

Хөдөлмөрийн хэлтэс нь төсвийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болон бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, мөнгөн хөрөнгө, нийт зардал, нийт хөрөнгийн 100 хувийг тус тус эзэлж байна.

Мөнгөн хөрөнгийн талаар

Хөдөлмөрийн хэлтэс нь 2015 онд үндсэн дансаар батлагдсан төсвөөс гадна НДС-аас 6,273.3 мянган төгрөгийн тэтгэмжийн мөнгө, мөн урьд оны авлага барагдаж 1.3 мянган төгрөг орж ирэн тэтгэмжийг олгосон байна. Нэмэлт санхүүжилтын дансаар урьд оны үлдэгдлээс сумдад "Ахуй үйлчилгээний төв" байгуулах зориулалтаар 176,340.0 мянган төгрөг, багаж тоног төхөөрөмж авах зориулалтаар 2,500.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 500.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-гаас "Алтай түншлэл-2015" үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зориулалтаар 8,200.0 мянган төгрөг, Дэлхийн зөн ОУБ-аас заалны түрээсийн мөнгө болох 120.0 мянган төгрөг, барилгын өргөтгөл барих зориулалтаар 30,000.0 мянган төгрөг, тусламжаар 7,360.0 мянган төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйлчилгээний зардалд 3,500.0 мянган төгрөг, ХЭДС-аас "Алтай түншлэл-2015" үзэсгэлэн худалдааны шагналд 150.0 мянган төгрөг, тендерийн баримт бичгийн үнэ 200.0 мянган төгрөг, нийт 228,870 мянган төгрөгийг оруулж, зориулалтаар нь 224,837.5 мянган төгрөгийг зарцуулж 4,032.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Зарцуулсан зардлаас онцолж дурдвал сумдад ахуй үйлчилгээний төв байгуулах зорилгоор хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сумдаас судалгаа авахад "зах зээлийн ханшаас өндөр үнэтэй, чанарын шаардлага хангахгүй байгаа, сургалтанд хамрагдсан иргэн байхгүй" гэсэн шалтгаанаар түрээсийн гэрээ хийх иргэн ховор байгаа нь уг ажил үр дүн муутай байгааг харуулж байна.

Тайлант хугацаанд нийт 528,704.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээ орж 505,348.5 мянган төгрөгийг зарцуулж нийт 23,355.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар

Тус байгууллагад тайлант хугацаанд үнэ төлбөргүй болон шилжиж ирсэн хөрөнгө байхгүй. Төсвийн хөрөнгөөр 9,919.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэн, хөрөнгийн элэгдлийг зохих хувь хэмжээгээр байгуулан нягтлан бодох бүртгэлд тусгасан.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 12,586.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 13,498.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, бараа материалын оны эцсийн үлдэгдэл 4,692.3 мянган төгрөг байна.

Оны эцэст хөрөнгийн тооллого хийсэн ба тооллогыг чанартай сайн гүйцэтгэсэн байна.

Өглөг, авлагын талаар

Авлагын эхний үлдэгдэл 1.3 мянган төгрөг байсныг барагдуулсан бөгөөд тайлант онд барилгын өргөтгөл бариулах зорилгоор 9 сард 30,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар авч 11 сард тендер зарлаж "Дөл Өөдөө" ХХК-г шалгаруулан улирлын шалтгаанаар 2016 оны 6 сарын 1-нд хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулан мөнгийг шилжүүлж тухайн компанид авлага үүсгэсэн байна. Мөн НДХ-ээс НДШ-ийн авлага 224.2 мянган төгрөг, цалингийн авлага 2.2 мянган төгрөгөөр үүссэн байна.

Харин өглөгийн тухайд оны эхний үлдэгдэлгүй бөгөөд тайлант оны эцэст 1,311.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, 164.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын өглөг, 1,208.0 мянган төгрөгийн урсгал засварын материалын өглөг нийт 2,683.8 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Аудитаар илэрсэн зөрчлүүд болон тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Хөдөлмөрийн хэлтсийн материаллаг түвшинг нийт орлогын 2 хувиар тооцож 10,574.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Ахлах мэргэжилтэн Н.Баярсайханы үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 76.7 мянган төгрөгийн цалин олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалт, ЭМС нийгмийн хамгаалалын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Давхардуулан олгосон цалин болох 76.7 мянган төгрөгийг суутган авч төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

2. Борлуулалтын цэг ажиллуулахдаа ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын сүлжээ хариуцсан менежерээр Ц.Баярмагнайг гэрээт ажилтнаар томилон 12 сард 500.0

мянган төгрөгний цалин олгосон нь Хөдөлмөрийн сайдын 2015 оны 3 сарын 13-ны өдрийн А/28 тоот "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай" тушаалын 1-р хавсралтын 4-р зүйлийн 4.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Үндэслэлгүй олгосон цалин болох 500.0 мянган төгрөгийг суутган авч төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3. Засгийн газрын тогтоолыг зөрчин "Хөдөлмөрийн хэлтсийн байрны өргөтгөлийн барилгын ажил"-ын гэрээг 2015 оны 12 сарын 18-нд байгуулсан нь Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилган, цаашид давтан гаргахгүй байх ажил зохион байгуул

4. Сумдад ахуй үйлчилгээний төв байгуулах зорилгоор хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сумдаас судалгаа авахад "зах зээлийн ханшаас өндөр үнэтэй, чанарын шаардлага хангахгүй байгаа, сургалтанд хамрагдсан иргэн байхгүй" гэсэн шалтгаанаар түрээсийн гэрээ хийгээгүй байгаа нь Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/221 тоот тушаал "Журам батлах тухай" -ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийг сумдад сайтар ойлгуулж, түрээсийн гэрээ хийгдээгүй байгаа тоног төхөөрөмжүүдийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллах.

5. Төсвийн тодотгол хийгдээгүй байхад урсгал санхүүжилтыг 13,633.6 мянган төгрөгөөр дутуу авсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Дутуу авсан санхүүжилт болох 13,633.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөх.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад 7,258.3 мянган төгрөгийн алдааг залруулсан болно. Залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр байгууллагуудын удирдлага анхаарлаа хандуулж шийдвэрлэх шаардлагатай. Тухайлбал:

- Ажилчдын амралтын хоногийг хуулийн хүрээнд зөв тооцож, олгох
- Санхүүжилтийг бүрэн авах талаар анхаарах, эсвэл тодотгол хийлгэх, төсвийг үндэслэлтэй бодитой төлөвлөх
- ХЭДС-аас хэрэгжүүлж байгаа "Борлуулалтын цэг" ажиллуулах ажилтанд урсгал төсвөөс цалин олгохгүй ба Хөдөлмөрийн сайдын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулах.
- Няrvын дансаар гүйлгээ хийхгүй, харилцагчийн дансаар гүйлгээг хийх.
- Өглөг, авлага үүсгэхгүй НББ-ийн тасралтгүй байх зарчмыг мөрдөж ажиллах.
- Эрх мэдлээ хэтрүүлэн ашиглахгүй байх
- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах

Дараа жилийн аудитаар авч үзэх асуудлууд

Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно. Дараа жилийн аудитаар барилгын өргөтгөлийн ажлын гэрээг дүгнэсэн байдал, ХЭДС-ийн борлуулалтын цэгийг ажиллуулахдаа хүнд цалин урамшуулал олгосон эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 21,468.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 576.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, 7,258.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Өмнөх шийдвэрийн хэрэгжилт

2014 оны Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй, 1,600.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсоныг бүрэн барагдуулж ажилласан байна. Зөвлөмжийн тухайд 2014 онд батлагдсан төсвийг 22,724.4 мянган төгрөгөөр дутуу авсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй ба 2015 онд мөн батлагдсан төсвийг 13,633.6 мянган төгрөгөөр дутуу олгож зөрчил давтан гарсан байна.

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Говь-Алтай аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгөхийг санал болгож байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, төлбөр зөрчлийн жагсаалт 1 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

БЭЛТГЭСЭН:

ШИНЖЭЭЧ

Г.ЭНХДЭЛГЭР

2016.02.03

Төлбөр зөрчлийн жагсаалт

№/0	Зөрчлийн		Шийдвэрийн		Нийт зөрчлийн мөнгөн дүн	Заглуулаа	Шийдвэр						үр өгөөж болох										
	Зөрчлийн үгээ	Зөрсөн хуулийн заалт	Харуудах эзэн	Заалт			Ахт			Албан шавардлага			Зөвлөмж		Санхүү	Санхүүбу							
							Улсын төсвийн орлого	Орон нутгийн орлого	СХС-0	Зөрчил өрчлөх	Заалт	Хариуцлаг а тооцох	Мөнгөн дүн	заалт									
Зөрчлийн нийт дүн					21,468.6	7,258.3					576.7			1.0			13,633.6		576.7				
1	Ахлах мэргэжилтэн Н.Баярсайханд үндсэн цалинг нь амралтын цалинтай давхардуулан 76.7 мянган төгрөг олгосон	Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, ЗМС нийгэмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт/ажил олгогч нь бүх ажилтана жил бүр эзлэгийн амралтаа заавал биеэр зөндүүлэх бололцоогоор хангаж эдгүүлдэг /-ыг, Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалт/ ажилтанд эзлэгийн амралтын хугацаанд нь эзлэгийн амралтын өлгөөр олгоно/-ыг,	Дараа М.Мянганбуу, Нягтлан бодогч С.Уранчимээ	Ажилчдын үндсэн цалинаг давхардуулан олгосон 76.7 мянган төгрөг, үндэслэлгүй олгосон 500.0 мянган төгрөгийн цалин, нийт 576.7 мянган төгрөгийн төлүүлж төсвийн орлого болгох.	76.7																76.7		
2	Борлуулалтын цэг ажиллуулахдаа ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын сүлжээ харуулсан менежерээр Ц.Баярмагнайга гэрээт ажилтнаар томилон 12 сард 500.0 мянган төгрөгийн цалин олгосон	Хөдөлмөрийн сайдын 2015 оны 3 сарын 13 ны өдрийн А/28 тоот "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай" тушаалын 1-р хавсралтын 4-р зүйлийн 4.1 дэх заалт /Борлуулалтын цагийг ажиллуулах зардлыг зөвхөн түрээсийн төлбөр болон урсгал зардал/ цахилгаан, дулаан, интернэт гэх мэт/-д зарцуулна. Борлуулалтын цэг дээр ажиллах борлуулалтын цалин урьмишуулал олгохуудээр буюу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог эзэл, санхүүгийн дэмжлэгт хамрагдан шийдвэр зарсан зарилтот бүтцийн ирээдүйг тодорхой хуваарийн дагуу ажиллуулах байдлаар зохион байгуулна/-ыг	Дараа М.Мянганбуу, Нягтлан бодогч С.Уранчимээ		500.0						500.0											500.0	
3	Засгийн газрын тасгаолыг зөрчин "Хөдөлмөрийн хэлтсийн байрны өргөтгөлийн барилгын ажил"-ын гэрээг 2015 оны 12 сарын 18-нд байгуулсан	Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалт /2015 оны 8 дугаар сарын 31-нээс хойш бариа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулахгүй байх, 2015 оны 8 дугаар сарын 31-нээс өмнө гэрээ байгуулж ажилласан нь буцаан санхүүжээдээгүй арга хэмжээний зардлыг 2016 оны төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах/-ыг	Дараа М.Мянганбуу, Нягтлан бодогч С.Уранчимээ	Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд сумдад хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжөөс түрээсийн гэрээ хийгээгүй байгаа тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилган, цаашид дагтан гэрээлэхгүй байх																			
4	Сумдаа ахуй үйлчилгээний төв байгуулах зорилгоор хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сумдаас судалгаа авахад "зах зээлийн ханшаас өндөр үнэтэй, чанарын шаардлага хангахгүй байна, сургалтанд хамрагдсан иргэд байхгүй" гэсэн шалтгаанаар түрээсийн гэрээ хийх ирэгэн ховор байгаа нь үг ажил үр дүн муутай байгааг харуулж байна	Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/221 тоот тушаал "Журам батлах тухай"	Дараа М.Мянганбуу, Нягтлан бодогч С.Уранчимээ											1.0									
5	Төсвийн тодотгол хийгээгүй байхад урсгал санхүүжилтыг 13,633.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн	Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалт /төсвийн ерөнхийлөн захиргагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох/-ыг	Дараа М.Мянганбуу, Нягтлан бодогч С.Уранчимээ	Зөвлөмжийг ТЕЗ-ийн нэгдсэн тайлангаар Сангийн яаманд өгөхөөр шийдвэрлэ	13,633.6												13,633.6						
6	ЖДҮД-ийн захирал Ц.Ачлтмаад шүүхийн шийдвэрээр тогтоогдсон нөхөн төлбөр болох 4,391.0 мянган төгрөгийн төсвөөс төлсөн.	Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 5 дахь заалт /Энэ хуулийн 496.1, 498.2, 498.3-т заасан этгээд өөрийн шүүдг санаатай буюу шлгдд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй/-ыг	Дараа М.Мянганбуу, Нягтлан бодогч С.Уранчимээ		4,391.0	4,391.0																	
7	Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийг 60.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, Авлагын тодруулгын тайланд 226.4 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 175.8 мянган төгрөгийг тус тус зөрүүтэй тайлагнасан.	Сангийн сайдын 2014 оны 5-р тушаалын 6-р хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"	Дараа М.Мянганбуу, Нягтлан бодогч С.Уранчимээ	Аудитын яцад залуулаа.	462.2	462.2																	
8	Үр дүнгийн тайланд 1,686.4 мянган төгрөгийн зардлыг, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 718.7 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус зөрүүтэй тайлагнасан		Дараа М.Мянганбуу, Нягтлан бодогч С.Уранчимээ		2,405.1	2,405.1																	

Зөвшөөрсөн

Дараа

М.Мянганбуу

Нягтлан бодогч

С.Уранчимээ

Бэлтгэсэн

Шинжлэгч

Г.Энэдэлээр

Талангусан:

Могой Морийн
дарга

М.Мянганбуу



Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл

Байгууллагын нэр: Хөдөлмөрийн хэлтэс

Тайлант огноо: 2015 оны 12 дугаар сарын 31

№	Сорил хийсэн дансны нэр	Аудитаар илэрсэн асуудал	Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө (материаллаг, материаллаг бус)	Аудиторын санал	Тухайн байгууллагын санал	Уулзалтын үр дүнгийн баталгаажуулалт
				(Бүртгэлийн бичилт, тооцоолол)	(Бүртгэлийн бичилт, тооцоолол)	
1	Зардал	Ахлах мэргэжилтэн Н.Баярсайханд үндсэн цалинг нь амралтын цалинтай давхардуулан 76.7 мянган төгрөг олгосон	Материаллаг бус нөлөөтэй	Төлбөрийн акт тогтоох	Хүлээн зөвшөөрсөн	2016 оны 2 сарын 4-ний дотор төлөх
2	Зардал	Борлуулалтын цэг ажиллуулахдаа ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын сүлжээ хариуцсан менежерээр Ц.Баярмагнайг гэрээт ажилтнаар томилон 12 сард 500.0 мянган төгрөгний цалин олгосон.	Материаллаг бус нөлөөтэй	Төлбөрийн акт тогтоох		
3	Зардал	Засгийн газрын тогтоолыг зөрчин "Хөдөлмөрийн хэлтсийн байрны өргөтгөлийн барилгын ажил"-ын гэрээг 2015 оны 12 сарын 18-нд байгуулсан.	Материаллаг бус нөлөөтэй	Албан шаардлага хүргүүлэх		
4	Зардал	Сумдад ахуй үйлчилгээний төв байгуулах зорилгоор хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сумдаас судалгаа авахад "зах зээлийн ханшаас өндөр үнэтэй, чанарын шаардлага хангахгүй байгаа, сургалтанд хамрагдсан иргэн байхгүй" гэсэн шалтгаанаар түрээсийн гэрээ хийх иргэн ховор байгаа нь уг ажил үр дүн муутай байгааг харуулж байна.	Материаллаг бус нөлөөтэй	Албан шаардлага хүргүүлэх		2015 оны 6 сарын 15-ны дотор хариуг ирүүлэх
5	Орлого	Төсвийн тодотгол хийгдээгүй байхад урсгал санхүүжилтыг 13,633.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн.	Материаллаг бус нөлөөтэй	Нэгтгэсэн тайлангаар Сангийн яаманд зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн	Хүлээн зөвшөөрсөн
6	Орлого, зардал	ЖДҮДТ-ийн захирал Ц.Ачитмаад шүүхийн шийдвэрээр тогтоогдсон нөхөн төлбөр болох 4,391.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн.	Материаллаг бус нөлөөтэй	Залруулга хийсэн	Хүлээн зөвшөөрсөн	Хүлээн зөвшөөрсөн.
7	Зардал	Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийг 60.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, Авлагын тодруулгын тайланд 226.4 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 175.8 мянган төгрөгийг тус тус зөрүүтэй тайлагнасан.	Материаллаг бус нөлөөтэй	Залруулга хийсэн	Хүлээн зөвшөөрсөн	Хүлээн зөвшөөрсөн.
8	Зардал	Үр дүнгийн тайланд 1,686.4 мянган төгрөгийн зардлыг, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 718.7 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус зөрүүтэй тайлагнасан	Материаллаг бус нөлөөтэй	Залруулга хийсэн	Хүлээн зөвшөөрсөн	Хүлээн зөвшөөрсөн.

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл хөтөлсөн шинжээч:
Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг зөвшөөрсөн:

Байгууллагын дарга (М.Мянганбуу)

Байгууллагын ня-бо (С.Уранчимэг)

Зөвшөөрөөгүй бол шалтгааныг бичнэ. /Тухайн байгууллагаас албан тоотгоор авна/.....

Анхан шатны хяналт хийсэн Аудитын менежер: Д.Дордэнчимэг Огноо: 2016.01.11

Хоёр дах шатны хяналт хийсэн аудитын менежер: Дарга, Тэргүүлэх аудитор Х.Тувшинбаяр Огноо:

Аудитын менежерийн санал
Тэргүүлэх аудиторын санал

Г.Энхдэлгэр

Шатны улам:
Хэлтсийн

Аудитын менежерийн дарга М.Мянганбуу





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

82091 Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, Баянхайрхан баг,
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.
E-mail: govialtai@audit.gov.mn

2016.02.03

№

09/01

Төсвийн орлого болгох тухай

Говь-Алтай аймгийн аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Ахлах мэргэжилтэн Н.Баярсайханы үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 76.7 мянган төгрөгийн цалин олгосон
- ✓ Борлуулалтын цэг ажиллуулахдаа ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын сүлжээ хариуцсан менежерээр Ц.Баярмагнайг гэрээт ажилтнаар томилон 12 сард 500.0 мянган төгрөгийн цалин олгосон, нийт 576.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, ЭМС нийгмийн хамгаалалын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт /ажил олгогч нь бүх ажилтанг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ /-ыг, Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалт/ ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно/-ыг, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 3 сарын 13-ны өдрийн А/28 тоот "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай" тушаалын 1-р хавсралтын 4-р зүйлийн 4.1 дэх заалт /Борлуулалтын цэгийг ажиллуулах зардлыг зөвхөн түрээсийн төлбөр болон урсгал зардал/ цахилгаан, дулаан, интернэт гэх мэт/-д зарцуулна. Борлуулалтын цэг дээр ажиллах борлуулагчид цалин урамшуулал олгохгүйгээр буюу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдах шийдвэр гарсан зорилтот бүлгийн иргэдийг тодорхой хуваарийн дагуу ажиллуулах байдлаар зохион байгуулна/-ыг тус тус зөрчсөн үйл ажиллагаа болжээ.

Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 15-р зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан

шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т / улсад болон байгууллагад хохирол учруулсан”-д төлбөрийн акт тогтооно/ гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Давхардуулан олгосон цалин болох 76.7 мянган төгрөг, үндэслэлгүй олгосон цалин 500.0 мянган төгрөг нийт 576.7 мянган төгрөгийг 2016 оны 5 сарын 15-ны дотор аймгийн төрийн сангийн татварын бус орлогын 050000982 тоот тоот дансанд оруулах

Дээрх төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2016 оны 5 дугаар сарын 15-ны дотор Говь-Алтай аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга М.Мянганбуу, нягтлан бодогч С.Уранчимэг нарт үүрэг болгов.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн 2.2 дахь заалтыг үндэслэн хариуцлага тооцох болно.

Шийдвэрийг эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор дээд албан тушаатанд гомдол гаргах эрхтэй.

АКТЫГ

ТОГТООСОН:

ЗӨВШӨӨРСӨН:

АУДИТЫН ГАЗРЫН

ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН

ШИНЖЭЭЧ



Г.ЭНХДЭЛГЭР

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

М.МЯНГАНБУУ

С.УРАНЧИМЭГ


ШИНЖЭЭЧ

Ц.САЙХАНЖАРГАЛ

АНХАН ШАТНЫ ХЯНАЛТ ХИЙСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭРДЭНЭЧИМЭГ





Г ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
М.МЯНГАНБУУ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

82091 Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, Баянхайрхан баг,
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2016.02.03 № 09/01

Зөрчил арилгах тухай

Говь-Алтай аймгийн аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Засгийн газрын тогтоолыг зөрчин "Хөдөлмөрийн хэлтсийн байрны өргөтгөлийн барилгын ажил"-ын гэрээг 2015 оны 12 сарын 18-нд байгуулсан.
- ✓ Сумдад ахуй үйлчилгээний төв байгуулах зорилгоор хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сумдаас судалгаа авахад "зах зээлийн ханшаас өндөр үнэтэй, чанарын шаардлага хангахгүй байгаа, сургалтанд хамрагдсан иргэн байхгүй" гэсэн шалтгаанаар түрээсийн гэрээ хийх иргэн ховор байгаа нь уг ажил үр дүн муутай байгааг харуулж байна.

Энэ нь: Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалт /2015 оны 8 дугаар сарын 31-нээс хойш бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулахгүй байх, 2015 оны 8 дугаар сарын 31-нээс өмнө гэрээ байгуулж гүйцэтгэл нь бүрэн санхүүжигдээгүй арга хэмжээний зардлыг 2016 оны төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах/-ыг, Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/221 тоот тушаал "Журам батлах тухай"-ыг тус тус зөрчсөн үйл ажиллагаа болжээ.

"Төрийн аудитын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд сумдад хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжөөс түрээсийн гэрээ хийгдээгүй байгаа тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилган, цаашид давтан гаргахгүй ажиллахыг аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга М.Мянганбууд үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.


Албан шаардлагын биелэлтийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн 2.2 дахь заалтыг үндэслэн хариуцлага тооцох болно.

ШИНЖЭЭЧ

Г.ЭНХДЭЛГЭР

АНХАН ШАТНЫГ ХЯНАЛТ ХИЙСЭН:
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭРДЭНЭЧИМЭГ





ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
М.МЯНГАНБУУ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

82091 Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, Баянхайрхан баг,
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2016.02.03 № 12
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, 15.2-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газраас аудит хийв.

Хөдөлмөрийн хэлтэс нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн тайланд аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

ГАА-2016/38/САГ-ТШЗ

2016.02.03

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Хөдөлмөрийн хэлтэс

Тайлангийн хэвсралт№1
2015.12.31

БАЛАНСЫН ЗҮЙЛ		АУДИТЛАГДСАН	
		Эхний	Эцсийн
30	ХӨРӨНГӨ		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		0.01
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31110	Төгрөг	-	-
31120	Гадаад валют	-	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	0.01
31210	Төгрөг	-	0.01
31211	Төрийн сангийн харилцах	-	0.01
33000	АВЛАГА	1,288.00	34,617,430.62
33500	Бусад авлага	1,288.00	34,617,430.62
33510	Байгууллагаас авах авлага	-	30,224,246.85
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,288.00	4,393,183.77
35	БАРАА МАТЕРИАЛ	5,604,153.33	4,692,303.33
35400	Хангамжийн материал	5,604,153.33	4,692,303.33
35410	Бичиг хэргийн материал	389,533.33	365,533.33
35420	Аж ахуйн материал	5,214,620.00	4,326,770.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	665,337,371.43	633,057,114.81
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	664,709,596.39	632,558,416.69
39201	Барилга байгууламж, орон сууц	577,160,850.00	577,160,850.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,449,733.80)	(71,613,082.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,932,362.00	67,932,362.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,039,585.51)	(25,939,528.32)
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	73,673,715.00	80,184,215.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,438,647.24)	(31,667,046.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшид	45,149,470.00	48,497,970.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,278,834.06)	(12,057,322.66)
39217	Ном	-	60,000.00
39300	Биет бус хөрөнгө	627,775.04	498,698.12
39301	Программ хангамж	929,000.00	929,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(301,224.96)	(430,301.88)
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	670,942,812.76	672,366,848.77
40	ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41300	Өглөг	-	2,683,833.84
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	1,311,233.84
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,372,600.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	2,683,833.84
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	2,683,833.84
5	Цэвэр хөрөнгө/өмч		
51	Засгын газрын хувь өрөлцоо	670,942,812.76	669,683,014.93
51100	Засгын газрын оруулсан капитал	683,634,465.97	683,634,465.97
51200	Хуримтлагдсан үр дүн	(12,691,653.21)	(13,951,451.04)
51210	өмнөх үеийн үр дүн	(12,691,653.21)	(14,387,123.73)
51220	Тайлант үеийн үр дүн	-	435,672.69
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
	Цэвэр хөрөнгө, өмчийн дүн	670,942,812.76	669,683,014.93
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН	670,942,812.76	672,366,848.77

Бэлтгэсэн

Шинжээч

Анхан шатанд хянасан

Аудитын менежер

Хүлээн зөвшөөрсөн

Нягтлан бодогч

Г.Энхдэлгэр

Д.Эрдэнэчимэг

С.Уранчимэг

АУДИТЛАГДСАН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Хөдөлмөрийн хэлтэс

Тайлангийн хэвсрэлт №2
2015.12.31

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
үйл ажиллагааны орлого		
31 ҮЛСҮЙН ТӨСВӨӨС	293,632,640.00	293,559,590.00
310001 Үлсын төсвөөс санхүүжих	293,632,640.00	293,559,590.00
32 Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,500,000.00	8,200,000.00
320002 Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,500,000.00	8,200,000.00
33 Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		6,273,253.00
330001 Нийгмийн даатгалын сангаас		6,273,253.00
Нэмэлт санхүүжилт	564,468,000.00	33,500,000.00
ЗГНХ Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдсан	564,468,000.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсвөт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн		33,500,000.00
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,660,700.00	179,810,000.00
350001 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		470,000.00
350003 Урьд оны хэмнэлтийн үлдэгдлээс		179,340,000.00
350004 Үнэ төлбөргүй орж ирсэн орлого	26,660,700.00	-
360001 Тусламжийн орлогын эх үүсвэрээс	530,000.00	7,360,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	896,791,340.00	528,702,843.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	212,627,587.27	230,650,638.12
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	191,235,898.84	207,572,753.00
210101 Үндсэн цалин	191,235,898.84	207,572,753.00
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,391,688.43	23,077,885.12
210201 Тэтгэврийн даатгал	21,391,688.43	15,208,619.48
210202 Тэтгэмжийн даатгал		1,592,285.13
210203 УОМШӨ-ний даатгал		1,961,556.41
210204 Ажилгүйдлийн даатгал		392,311.28
210205 Эрүүл мэндийн даатгал		3,923,112.82
21 Урсгал зардал	696,855,405.94	297,616,532.19
2103 Байр ашиглалттай холбоотой зардал	27,555,351.00	19,158,180.00
210301 Гэрэл цахилгаан	3,530,588.00	1,385,583.00
210302 Тулш халаалт	22,966,720.00	17,013,117.00
210303 Цэвэр бохир ус	1,058,043.00	759,480.00
2104 Хангамж, бараа материалын зардал	19,857,570.75	12,023,020.00
210401 Бичиг хэргийн материал	4,827,880.76	3,007,350.00
210402 Тээвэр шатахуун	6,309,000.00	3,447,100.00
210403 Шуудан холбоо, интернетийн төлбөр	5,167,844.99	3,462,820.00
201404 Ном хэвлэл	78,800.00	35,100.00
210406 Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	3,474,045.00	2,070,650.00
2105 Нормативт зардал	5,251,300.00	-
210502 Хоол хүнс	4,126,300.00	-
210503 Нормын хувцас зөөлөн эдлэл	1,125,000.00	-
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,010,000.00
210604 Урсгал засвар	-	5,010,000.00
2107 Томилголт, зочны зардал	5,077,600.00	2,009,660.00
210702 Дотоод албан томилголт	5,077,600.00	2,009,660.00
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	40,869,914.63	40,726,766.10
210801 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	535,000.00	7,000.00
210802 Даатгалын үйлчилгээ		192,480.00
210805 Тээврийн хэрэгслийн татварын зардал	350,000.00	-
210807 Газрын төлбөр		23,500.00
210810 Төлбөр хураамж болон бусад зардал	811,300.00	-
210826 Бараа материал акталсны зардал	517,916.67	-
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	38,655,697.96	40,503,786.10
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	589,872,383.58	207,594,083.00
210901 Төсвийн урамшуулалын зардал		184,238,500.00
210907 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,910,000.00	-
210911 Төвлөрсөн арга хэмжээ	390,844,500.00	-
Төвлөрүүлэх шилжүүлэг тусламж	197,117,883.56	23,355,583.09
214 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	8,371,286.00	11,094,823.00
2141 нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээ	-	6,273,253.00
214105 Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэвэр		6,273,253.00
214107 Жирэмсэн амарсны тэтгэмж		-
2143 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	8,371,286.00	4,821,570.00
214308 Нэг удаагийн тэтгэмж, урамшуулалын зардал	8,371,286.00	4,821,570.00
2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	909,482,993.21	528,267,170.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(12,691,653.21)	435,672.69
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	(12,691,653.21)	435,672.69

Бэлтгэсэн
Шинжээч
Анхан шатанд хянасан
Аудитын менежер
Хүлээн зөвшөөрсөн
Нягтлан бодогч

Г.Энхдэлгэр
Эрдэнэчимэг
С.Уранчимэг

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: Хөдөлмөрийн хэлтэс

Тайлангийн хэвсрэлт №3
2015.12.31

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
31 Үлсын төсвөөс	293,632,640.00	293,559,590.00
310001 Үлсын төсвөөс санхүүжих	293,632,640.00	293,559,590.00
32 Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,500,000.00	8,200,000.00
320002 Орон нутгийн хөвжлийн сангаас санхүүжих	11,500,000.00	8,200,000.00
33 Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,095,844.00	6,273,253.00
330001 Нийгмийн даатгалын сангаас	6,095,844.00	6,273,253.00
Нэмэлт санхүүжилт	564,468,000.00	33,500,000.00
ЗГНХ Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдааг	564,468,000.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсвөөт тусгагдсан төсвөөс	0.00	33,500,000.00
35 Төсвөөт байгууллагын үйл ажиллагаанаас		179,811,288.00
350001 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		471,288.00
350003 Урьд оны хэмнэлтийн үлдэгдлээс		179,340,000.00
360001 Тусламжийн орлогын эх үүсвэрээс	530,000.00	7,360,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	876,226,484.00	528,704,131.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	212,649,359.45	233,956,834.90
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	191,340,396.85	210,654,702.93
210101 Үндсэн цалин	191,340,396.85	210,654,702.93
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,308,962.60	23,302,131.97
210201 Тэтгэврийн даатгал	21,308,962.60	15,432,866.33
210202 Тэтгэмжийн даатгал		1,592,285.13
210203 ҮОМШӨ-ний даатгал		1,961,556.41
210204 Ажилгүйдлийн даатгал		392,311.28
210205 Эрүүл мэндийн даатгал		3,923,112.82
Урсгал зардал	663,811,924.55	294,747,296.09
2103 Байр ашиглалттай холбоотой зардал	27,555,351.00	19,158,180.00
210301 Гэрэл цахилгаан	3,530,588.00	1,385,583.00
210302 Түлш халаалт	22,966,720.00	17,013,117.00
210303 Цэвэр бохир ус	1,058,043.00	759,480.00
2104 Хангамж, бараа материалын зардал	18,966,859.99	10,908,570.00
210401 Бичиг хэргийн материал	4,806,415.00	2,818,750.00
210402 Тээвэр шатахуун	6,309,000.00	3,447,100.00
210403 Шуудан холбоо, интернетын төлбөр	5,167,844.99	3,462,820.00
201404 Ном хэвлэл	153,800.00	95,100.00
210406 Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	2,529,800.00	1,084,800.00
2105 Норматив зардал	5,336,300.00	
210501 Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл		-
210502 Хоол хүнс,	4,211,300.00	-
210503 Нормын хувцас зөөлөн эдлэл	1,125,000.00	-
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	920,000.00	43,759,000.00
210601 Багаж, техник, хэрэгсэл		9,859,000.00
210602 Тавилга	920,000.00	-
210604 Урсгал засвар		33,900,000.00
2107 Томилолт, зочны зардал	4,997,600.00	2,009,660.00
210702 Дотоод албан томилолт	4,997,600.00	2,009,660.00
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	1,696,300.00	222,980.00
210801 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	535,000.00	7,000.00
210802 Даатгалын үйлчилгээ		192,480.00
210805 Тээврийн хэрэгслийн тэтгэврийн зардал	350,000.00	-
210807 Газрын төлбөр		23,500.00
210810 Төлбөр хураамж болон бусад зардал	811,300.00	-
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	589,872,383.56	207,594,083.09
210901 Төсвийн урамшуулалын зардал		184,238,500.00
210907 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	191,000.00	-
210911 Төвлөрсөн арга хэмжээ	390,844,500.00	-
Төвлөрүүлэх шилжүүлэг тусламж	197,117,883.56	23,355,583.09
214 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	14,467,130.00	11,094,823.00
2141 нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээ	6,095,844.00	6,273,253.00
214105 Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэвэр		6,273,253.00
214107 Жирэмсэн амаржсны тэтгэмж	6,095,844.00	-
2143 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	8,371,286.00	4,821,570.00
214308 Нэг удаагийн тэтгэмж, урамшуулалын зардал	8,371,286.00	4,821,570.00
2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	876,461,284.00	528,704,130.99
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)-(II)	(234,800.00)	0.01
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	(234,800.00)	0.01
Заруу		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.01

Бэлтгэсэн

Шинжээч

Анхан шатанд хянасан

Аудитын менежер

Хүлээн зөвшөөрсөн

Нягтлан бодогч

Г.Энхдэлгэр

Д.Эрдэнэчимэг

С.Уранчимэг

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Хөдөлмөрийн хэлтэс

Тайлангийн хавсралт №4
2015.12.31

код	51100	51200	51	
Үзүүлэлт	засгийн газрын сан	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн	
1	2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	683,634.465.97	(12,691.653.21)	670,942,812.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(1.695.470.52)	(1,695,470.52)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	683,634.465.97	(14.387.123.73)	669,247,342.24
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
7	Тайлант үеийн үр дүн		435,672.69	435,672.69
8	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	683,634,465.97	(13,951,451.04)	669,683,014.93

Бэлтгэсэн

Шинжээч

Анхан шатанд хянасан

Аудитын менежер

Хүлээн зөвшөөрсөн

Нягтлан бодогч

Г.Энхдэлгэр

Д.Эрдэнэчимэг

С.Уранчимэг